


7. Хөтөлбөрийн нэгтгэл

Энэхүү модулийн зорилго нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө бүртгэх, удирдах юм. ДБУМС-д сургалтын хөтөлбөр шинээр үүсгэх, засах, нэмэлт өөрчлөлт оруулах, баталгаажуулах, устгах, архивлах зэрэг үйлдлийг их, дээд сургууль, коллеж хийж гүйцэтгэх ба мэргэжлийн чиглэлийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг ДБУМС-ээр автоматаар шалгаж баталгаажуулан БШУЯ, түүний харьяа байгууллага өөрийн эрх үүргийн хүрээнд хөтөлбөрийн холбогдох мэдээллийг харах, хянах ба улсын хэмжээний их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, real, статистик, аналитик тайлан харах, татах боломжийг бүрдүүлэх юм.



Сургалтын хөтөлбөрийн мэдээлэл

№	Талбар	Тайлбар	Жишээ
1.	Сургалтын байгууллага	Сургалтын байгууллагын нэр	АШУҮИС
1.	Сургалтын нэгж	Сургалтын хөтөлбөрийн харьяалагдах сургалтын нэгжийг сонгоно.	Бакалаврын сургалтын алба
2.	Боловсролын түвшин	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бакалавр, магистр, доктор гэсэн боловсролын түвшнээс сонгоно.	Бакалавр
3.	Мэргэжлийн чиглэл	Тусгай зөвшөөрлөөр авсан мэргэжлийн чиглэлээс сонгоно. Сонгосон боловсролын түвшнээс хамаарч харгалзах мэргэжлийн чиглэлийг сонгох боломжтой байна.	011101 - Боловсрол судлал
4.	Индекс	Хөтөлбөрийн кодыг оруулна.	D011101-01

5.	Хөтөлбөрийн нэр	Сургууль дээр хэрэгждэг хөтөлбөрийн үндсэн нэрийг оруулна.	Боловсрол судлал - Өдөр
6.	Хөтөлбөрийн төрөл	Үндсэн, суурь, бэлтгэл, гадаадын хөтөлбөр эсэхийг сонгоно.	Үндсэн хөтөлбөр
7.	Сургалтын хэлбэр	Сонгогдсон мэргэжлийн чиглэлээс шалтгаалж өдөр, орой, эчнээ гэсэн сонголт байна.	Өдөр
8.	Төлөв	Сургалтын хөтөлбөрийн төлвийг харуулна. Засварын горим, идэвхтэй, идэвхгүй, зогсоосон гэсэн төлвөөс хамаарч бусад суралцагч элсүүлэх, төгсгөх, шилжүүлэх зэрэг үйлдлүүд ажиллах боломжтой байна. Идэвхтэй төлөвт оруулсан сургалтын хөтөлбөрт шинэ суралцагч элсүүлэх боломжтой байна.	Идэвхтэй
9.	Үе шаттай эсэх	Тухайн сургалтын хөтөлбөр нь анги, дамжаа, курсын гэсэн хатуу шатлалаар явдаг бол Тийм сонголтыг сонгоно. Хичээл чөлөөтэй сонгох зарчмаар хэрэгждэг сургалтын хөтөлбөртэй бол Үгүй сонголтыг сонгоно.	Тийм
10.	Элсэгчийн боловсролын түвшин	Тухайн сургалтын хөтөлбөрт элсэхийн тулд элсэгчийн эзэмшсэн байвал зохих боловсролын түвшинг сонгоно.	Бүрэн дунд
11.	Улирлын төрөл	Сургалтын хөтөлбөр нь хичээлийн жилд орох улирлын төрлийг сонгоно.	Семистер
12.	Боловсролын зэрэг	Сургалтын хөтөлбөр төгсөхөд олгох боловсролын зэргийг сонгоно.	Бакалаврын зэрэг
13.	Сургалтын хугацааны хязгаартай эсэх	Сургалтын нийт үргэлжлэх хугацаа нь хатуу биш бол Үгүй	Үгүй

		Сургалтын нийт үргэлжлэх хугацаа нь уян хатан бол Тийм сонголтыг сонгоно.	
14.	Сургалтын хугацаа	Дээрх сонголтоос шалтгаалж хугацааг оруулна.	2,5- 4 жил
15.	Агуулгын багтаамж	Тухайн сургалтын хөтөлбөрөөр олгох агуулгын багтаамжийг багц цагаар оруулна.	120 багц цаг